

ХУВЬСАЛЫН ОНОЛЫН ХУУДУУНЫ ТУХАЙ АСУУДАЛД.

"К проблеме об изыне теории эволюции"

Ц.Эрдэнэбат. ХААИС-ийн багш, докторант
Г.Эрдэнэбаяр. МУИС. НШУС. Философийн тэнхим. доктор

Түлхүүр үгс: Australopithecine "өмнөд африкийн сармагчин", Homo habilis "чадварлаг хүн", Homo erectus "босоо явагч хүн", Homo sapiens "оюун ухаант хүн, хүний үүсэл,

Бүх мэдлэг бол хүмүүн өөрөө өөрийгөө танин мэдэх гэсэн хэрэгцээ, шаардлагын уриа дуудлага бүхний хариулт болон үүсэн хөгжжээ. Хүн өөрөө өөрийгөө танин мэдэх зорилгоор өөрийгөө хийгээд өөртэйгөө төсөөтэй амьтдыг ажиглаж, судалж, эргэцүүлж, бодож боловсруулж бүтээсэн бүх мэдлэгийг хүн судлал буюу антропологи гэж нэрлэдэг бөгөөд өөрөө өөрийгөө танин мэдэх гэсэн эрэл хайгуул философи гэж нэрлэж буй ухаан.

Цаг хугацааны дотор болж байгаа өөрчлөлтийн үйл явцыг хувьслын онол тайлбарладаг билээ. Материалист философи нь XVIII зууны II хагас, XIX зууны I хагаст Фейрбах, Шеллинг, Гегель, Фихте болон Кант гэх мэт сэтгэгчид болох Германы сонгодог философиос ул үндэстэйг Ф. Энгельс шинэ европын хөгжилд чиг шугамыг тодорхойлсон гэж бүтээлүүддээ дурдсан байдаг¹.

Марксист сургаал гарахад тухайн үед байгаль шинжлэлд гарсан ололтууд ихээхэн нөлөө үзүүлсэн. Жишээлбэл үүнд: Амьд биетүүд эсээс тогтдог болох эсийн онол, энерги хадгалагдах хууль, Ч.Дарвины гаргасан хувьслын онол зэрэг юм. Дээрх дурдсан нээлтүүдээс марксизмд ихээхэн нөлөө үзүүлсэн онол бол Ч.Дарвины үндэслэсэн хувьслын онол болохыг материализмыг үндэслэгчид онцолдог. Уг онолын үндсэн агуулга нь аливаа амьд биетүүд үүслээсээ байнга хувьсаж байдаг бөгөөд энэ тухай "Зүйлүүдийн үүсэл" бүтээлдээ өгүүлсэн.

Туркийн эрдэмтэн Харун Яха (Harun Yahya) материализмын нийгмийн үзлийг шүүмжлэх үүднээс XIX зуунд Германд бий болсон фашист дэглэмийн эх үндэс нь дарвинизм болохыг онцлоод "Дарвинистууд нацист үзэл сурталд нөлөөлсөн байх боломжтой. Дэлхийн II дайныг өдөөгч Адольф Гитлер (Adolf Hitler), Альфред Розенберг (Alfred Rosenberg) нарын гүйцэлдүүлсэн энэ онолын нэг шалгуур нь "Зүйлүүдийн үүсэл" зохиолд нилээдгүй удаа давтагддаг. Арьстнуудын хоорондох амьдралын төлөөх тэмцэл, "байгалийн шалгарал" гэх мэт ойлголттой адил концепцийг гаргасан"² гэж тэмдэглэсэн байдаг.

Дарвины хувьслын онолыг социаль дарвинизм болохынх нь хувьд фашизмыг баруун жигүүр, коммунизмыг зүүн жигүүр гэж зүйрлэсэн.

К.Маркс, Ф.Энгельс нар Ч.Дарвины "Зүйлүүдийн үүсэл" сургаалтай танилцсан дариудаа "Диалектик материалист" философийн сургаалынхаа гол баримжаагаа болгосон ба Ч.Дарвины хувьсалын онолын нөлөөллийн дор бичсэн "Байгалийн диалектик" зохиолын "Мич хүн болж хувирахад

¹ www.philosophy.ru

² Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001.p. 17

хөдөлмөрийн гүйцэтгэсэн үүрэг" бүлэгт Ф.Энгельс уг онолын хэрэглээн дэх өөрийн оролцоог дүрслэн харуулахыг хичээж Ч. Дарвиныг ихэд магтсан байдаг. Маркс, Энгельс, оросын коммунистууд болох Г.В.Плеханов, В.И.Ленин, Л.Тройцкий, И.В.Сталин нар Ч.Дарвины хувьслын онолыг ихэд талархан хүлээн зөвшөөрдөг байжээ. Тэдний үзлээр "Хөгжил нь шинэ зүйлийн тодрол мөн гэдгийн хурц тод гэрчилгээ амьдралын үүсэл ба хөгжил юм. Анхны хамгийн энгийн биетээс одоо цагийн амьтан, ургамлуудыг хүртэлх амьдралын хөгжил бол хөгжлийг хуучин зүйлийн мөхөл ба шинэ зүйлийн үүсэн гарах явдал гэж ойлгох диалектик ойлголтын хамгийн тод баталгаа болж байна"¹ гэж диалектик материалист философийн ном зохиолуудад онцлон тэмдэглэн бичиж үлдээсэн нь үүний нотолгоо юм.

"Хөгжил бол хуучин зүйл мөхөж шинэ зүйл үүсэх процесс"² гэж үзэх материализмын хувьслын үзэл санааг илэрхийлэх сургаалууд нь Харун Яхагийн үзэлд эсрэгээрээ тайлбарлагдсан байдаг. Орчин үеийн биологич Харвардын их сургуулийн эрдэмтэн Стивен Джей Гоулд (Stephen Jay Gould)³ мөн Нью Йорк дах Америкийн музейн судлаач Нильс Элдредж (Niles Eldredge)⁴ нар Ч.Дарвины онол маш олон зүйлийг тайлбарлаж чадаагүй талаар, хувьслын үйл явцын талаарх тайлбар ихэнх тохиолдолд зөрчилд ордогийг өөрсдийнхөө бүтээлүүдэд олон жишээгээр нотолжээ. "Конец науки" номны зохиолч, сурвалжлагч Джон Хорган хувьслын онолын талаар Стивен Джей Гоулдтай хийсэн сурвалжлагын талаар өөрийн номондоо "Бид Ч.Дарвины онолд хэрэглэгддэг бодгалиудын дасан зохицохын төлөөх тэмцлийн талбарт зүйлүүдийн хувирал гэдгийг тайлбарлах боломжгүй" гэдэг бол өнөөгийн бидний хамгийн чухал санаа⁵ гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Лев.Тройцкий: "Амьд материйн бүхий л хүрээнд диалектикийн хамгийн их баяр баясал нь Дарвины нээлт юм"⁶ гэсэн бол Дарвины сургаалыг судалж эзэмшсэн мэдлэг боловсрол нь коммунизм хэлбэршүүлэн байгуулахад гол үүрэгтэй болохыг онцгой анхааран үзэж байсан Сталиныг залуудаа шашин шүтдэг байсан ч Ч.Дарвины онол, бүтээлийг судалснаар шашингүйн үзэлтэн болсон⁷ гэж түүхийн ном зохиолуудад тэмдэглэсэн байдаг. Мөн Хятад дахь коммунист дэглэмийг үндэслэгч Мао: "Хятадын социализм нь хувьслын онол болон Дарвины үзэл дээр тулгуурласан" гэж тунхаглаж байжээ.Ч. Дарвины хувьсалын онол нь нийгмийн болон байгалийн хөгжилйн тухай сургаалуудад гол тулгуур болохыг олон улс төрчид, сэтгэгчид хүлээн зөвшөөрч байсныг дээрх жишээ өгүүлж байна.

К.Маркс өөрийн "Капитал" бүтээлийнхээ анхны хэвлэлийн нүүрэн талын эхэн дээд талд дарвинизм нь материализм болон коммунизмд нэг маш чухал хөрс суурь болсоныг онцлоод "Хүндэтгэн бишрэгчээс Ч. Дарвинд"⁸ гэж өөрийн гараар бичиж хаяглан илгээж байсан нь гарцаагүй Дарвины онолыг материализмын үндсээ болгосон гэдэгтэй маргашгүй юм.

¹ "Диалектик материализм" УБ. 1955. 142 дахь тал

² Мөн номны 147 дахь тал

³ Джон Хорган "Конец науки" Санкт Петербург. 2001. с.195

⁴ Джон Хорган "Конец науки" Санкт Петербург. 2001.с.196

⁵ Джон Хорган "Конец науки" Санкт Петербург. 2001. с.202

⁶ www.evolutiondeceit.com

⁷ www.websophia.com/aphorisms/science.html

⁸ Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001. 28 p

Өнөөдөр ч гэсэн уг онол нь хүлээн зөвшөөрөгддөг. Английн натуралист Ч.Дарвин нь хэзээ ч биологийн боловсролд суралцаж байгаагүй нэгэн аж. Тэр зөвхөн байгалийг сонирхогч бөгөөд HMS гэж нэрлэгдэх хөлөг онгоцны багийн сайн дурын гишүүнээр элсэн 1832 онд Англиас хөлөг эхлэн таван жилийн турш дэлхийн янз бүрийн орнуудыг тойрон аялалаа. Ч.Дарвины онол нь ямар нэгэн шинжлэх ухааны болон туршлагад үндэслэгдээгүй гэж Харун Яха ч тэр үедээ алдартай туршлагад биологичидоос тусламж авсны үндсэн дээр дээрх онолдоо материалист хандуулсан.

Ч.Дарвины онолын гол агуулга нь бодгалиудын чанар нь дараагийн үедээ шилжих хамгийн сайн арга бол амьдарч буй орчиндоо дасан зохицох чадвар юм. Эдгээр нэмэгдэх давуу чадварууд нь тусгаар зүйлүүдэд шилжихдээ өмнөх өвөг дээдсээсээ бүхэлдээ өөрчлөгдөж байдаг¹ гэсэнд оршино. Тэрээр байгалийн шалгарлын хувьсал гэж энэ үйл явцыг нэрлэснээр "зүйлүүдийн үүсэл" ийн шалтгаан, хөдөлгөгч хүчийг олсон гэдгийг ухааржээ. Ч.Дарвин энэ тухай өөрийнхөө үзэл баримтлалыг 1859 онд хэвлэгдсэн "Байгалийн шалгарлын тусламжтайгаар зүйлүүдийн үүсэх нь" гэж нэрлэгдсэн номондоо тусгасан.

Тухайн үедээ Ч.Дарвин өөрийн онолоо гаргахдаа нилээдгүй асуудалтай тулгарч байсан тухайгаа "Онолын бэрхшээлтэй байдал" гэсэн бүлэгтээ гаргасан. Эдгээр бэрхшээлтэй шинж нь олдворын баримтууд, амьдран буй зүйлүүдийн бүх эрхтэн, ялангуяа "нүд" болохыг онцолсон. Америкийн физикч Липсон (Lipson) Ч.Дарвины "бэрхшээлт байдал" гэсэн ойлголтод дараах тайлбарыг хийсэн байдаг. Энэ нь би "Зүйлүүдийн үүсэл бүтээлийг уншиж байхдаа Ч.Дарвин өөрийгөө төсөөлж байснаасаа илүү итгэл муутай байсаныг мэдэрсэн. "Онолын бэрхшээлт байдал" гэх бүлэгтээ тэрээр өөрийн эргэлзээгээ харуулсан байдаг. Би физикч болохынхоо хувьд "нүд" хэрхэн бий болсон гэдэгт зохих тайлбарыг өгсөн нь миний сонирхлыг ихэд татсан"² гэж тэмдэглэжээ.

Ч.Дарвины онолын үүднээс өнөөгийн хүн нь сармагчны зүйлийн амьтнаас үүсэлтэйг өдгөө ч зааж сургасаар байгаа. Сармагчин хүн болох энэ үйл явцыг 4-5 сая жилд хамааруулан, энэ үйл явц үндсэндээ 4 үе шатыг дамждагаар тайлбарладаг. Эдгээр үе шатууд нь:

- Australopithecine "өмнөд африкийн сармагчин"
- Homo habilis "чадварлаг хүн"
- Homo erectus "босоо явагч хүн"
- Homo sapiens "оюун ухаант хүн"³ гэсэн дэс дараалалтайгаар

хүний хувьсал, үүслийг тодорхойлжээ.

Хувьслын онолчид "Өмнөд африкийн сармагчин" гэсэн утга бүхий Australopithecus гэж хүний хамгийн анхны өвгийг тодорхойлсон. Энэ амьтан нь одоогоос 4 сая жилийн тэртээгээс 1 сая жил хүртэлх хугацаанд амьдарч байсан. Australopithecus "өмнөд африкийн сармагчин" нь дотроо хэд хэдэн төрөлд хуваагддаг бөгөөд зарим эрдэмтэд тэдгээр төрлүүдийг өөр хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй мэтээр тайлбарладаг. Бүх

¹ Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001. p. 38

² Max Planck "A physicist's view of Darwin's Theory" Evolution Trends in Plants. Vol 2в №1в 1988. p. 6

³ Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001. p. 86

Australopithecus зүйлүүд нь өнөөгийн сармагчин юм. Тэдний тархины хэмжээ нь өнөөгийн шемпанзегийн тархинаас жижгэвтэр, зарим нь ижил байдаг. Тэдний богино хөл, урт гар, нүдний ухархай, урд шүд, гавлын яс, *mandibular* бүтэц зэрэг нь өнөөгийн сармагчнаас ямар ч ялгаа байхгүй¹ гэж тодорхой олдворууд дээр тулгуурлан хүний өвөг биш гэж дүгнэсэн нь Харун Яхагийн баталгааны нэгээхэн хэсэг юм.

Англи болон Америкийн эрдэмтэд Л. С. Зукерман (Lord Solly Zuckerman) мөн профессор Чарльс Окснард (Charles Oxnard) зэрэг таван мэргэжилтнүүд Английн засгийн газрын санхүүгийн ивээн тэтгэлгээр 15 жилийн судалгааны үндсэн дээр *Australopithecus* нь энгийн нэгэн сармагчны зүйл болохыг нотолсон² байна.

Хувьслын онолчдын үзлээр, *Australopithecus*-н дараагийн үе нь *Homo habilis* "чадварлаг хүн" юм. *Homo habilis*-н тархины багтаамж нь *Australopithecus*-с хоёр дахин том гэж тодорхойлдог ч зарим тохиолдолд уг зүйлийг бусад зүйлүүдээс ялгасан нь маргаантай байдаг гэнэ. *Homo habilis* ангилалыг 1960-аад оны үед судлаачид бүхэл гэр бүлээрээ ан хийж амьдардагаар төсөөлөн тайлбарласан. *Homo habilis*-н тархины багтаамж нь их байсны зэрэгцээ, босоо явж чаддаг, чулуун болон модон багаж ашигладаг болохыг дүрсэлэн бичижгээдэг. 1980-д оны сүүлээр ухаж гаргасан шинэ олдворуудын үндсэн дээр уг дүрслэл бүрмөсөн өөрчлөгдсөн. АНУ-ын эрдэмтэд болох Вернард Вуд (Bernard Wood), Лорин Брас (C. Loring Brace) нарын судлаачид шинэхэн олдворуудыг судалснаар *Homo habilis* нь *Australopithecus*-тэй нийтлэг шинж чанараараа адил байсан учир "Өмнөд Африкийн багаж ашигладаг сармагчин" гэсэн утгатай *Australopithecus* -г "Багаж зэвсэг ашигладаг хүн" гэсэн утгатай *Homo habilis*-н ангилалд нэгтгэсэн³ байна.

Судалгааг эрчимтэй явуулсны дүнд Америкийн антропологч Холли Смит (Holly Smith) 1990 онд *Homo habilis* нь "Homo" биш, өөрөөр хэлбэл хүн биш, харин сармагчин гэсэн дүгнэлт хийсэн. Тэрээр энэ дүгнэлтээ гаргахын сацуу *Australopithecus* болон *Homo habilis*-н олдвор дахь шүдний хөгжлийн хэв маягаар нь тэдгээрийг Африкийн сармагчин гэж ялган, харин хувьслын онолчдын гаргасан дараах хоёр шат болох *Homo erectus*, *Neandarthalsis* -ууд нь хүний ангилалд багтаж болохыг нотолсон⁴ ажээ. Энэ нотолгоог гаргасан жил Fred Spoor, Bernard Wood болон Frans Zonneveld бусад судлаачид өөр өөр аргаар судалсны үр дүнд дээрхийн адил нэг дүгнэлтэд хүржээ⁵.

Фрейд Спур (Fred Spoor), Bernard Wood болон Франс Зонвелд (Frans Zonneveld) нар *Homo habilis*-н ангилалд судалгаа хийсэнээр орчин үеийн сармагчингуудтай адил болохыг тогтоон, *Homo erectus*-н чихний дотоод суваг нь орчин үеийн хүнийхтэй адил болохыг баталсан. Тэд эндээс дараах хоёр дүгнэлтийг хийжээ. Үүнд:

¹ That book. P. 88

² That book. P. 89

³ Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001. p.89-92

⁴ www.evolutiondeceit.com

⁵ Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001.p. 92

1. Homo habilis гэж нэрлэсэн амьтны олдвор нь үнэндээ "Homo" хүн гэсэн ангилалд хамаарагдахгүй, харин Australopithecus буюу сармагчны төрөлд хамаарагдана.

2. Эдгээр Homo habilis, Australopithecus нар нь алхах чадвар тэрчлэн араг ясны шинжээрээ юутай ч хүнтэй холбоогүй¹ гэж дүгнэсэн байна.

Харин хувьслын онолчдын үзлийн үүднээс "Homo" зүйл нь эхлээд Homo erectus, дараа нь Homo sapiens болон Neandarthalsensis хүн, хожмоо Cro-Magnon хүн, эцэст нь орчин үеийн хүн гэж ангилдаг. Гэсэн хэдий ч эдгээр ангиллууд нь бодит байдалдаа зөвхөн хүний "арьстны" эх үүсэл нь гэдгийг Харун Яха онцолсон байсан.

Homo erectus-н "босоо явагч хүн"-ий тархины багтаамж нь 900-1100 cc бөгөөд энэ хэмжээ нь орчин үеийн дундаж хүний тархины багтаамжаас үл ялиг жижгэвтэрийг тогтоосон. Гэвч өнөөдөр дэлхий дээр амьдарч буй олон хүний тархины багтаамж Homo erectus-тэй адил байдаг² гэсэн дүгнэлт хийжээ.

Мөн Homo erectus, Homo sapiens нь өдгөө ч зарим улс орнуудад амьдардаг үндэстнүүдтэй ижил шинж чанарыг агуулж байгааг Connecticut-н их сургуулийн профессор William Laughlin³ судлан гаргав.

American scientist сэтгүүлд эдгээр хүний үүслийн асуудлуудыг нэгтгэн 2000 онд уг асуудлыг шийдэх зорилгоор бага хурлыг зохион байгуулав. Энэ бага хурлаар Камбераны их сургуулийн эрдэмтэн Алан Торн (Alan Thorne), Мичиганы их сургуулийн багш Милфорд Волпоф (Milford Wolpoff) нар нилээдгүй асуудлыг хөндөн тавьж хэлэлцүүлэн, Homo erectus нь тусгаар зүйл болох баталгаа байхгүйг, мөн өмнөх эрдэмтэдийн хийсэн алдааны талаар маргалдан, "Homo" төрлийн бүх гишүүд 2 сая жилийн өмнөөс өдгөө хүртэл тогтмол өөрчлөгдсөн бол, харин Homo sapiens нь хувьсаж өөрчлөгдсөнгүй, дэлхийгээр тархсан болохыг илчлэн⁴ харуулсан байна. Энэ бага хурлын хэлэлцүүлэгийн үр дүнд "Homo erectus" нь оршин байгаагүй гэсэн дүгнэлтэд хүржээ.

Дээрх бүгдээс дүгнэхэд Australopithecus, Homo erectus, Homo habilis зэрэг нь палентологчдын судалснаар нэгэн цаг хугацаанд дэлхийн өөр өөр бүс нутагт амьдарч байсан. Цаашлаад Homo erectus гэж ангилсан энэ зүйл нь орчин үе хүртэл амьдарч байсан. **Homo sapiens neanderthalsensis болон Homo sapiens sapiens /орчин үеийн хүн/ нь нэгэн ижил бүсэд зэрэгцэн амьдарч байжээ гэж дүгнэсэн.**

Философи нь юмс үзэгдлийн ерөнхий холбоо харилцааг ухаарах сэтгэхүйн арга барил төдийгүй, хүн өөрийгөө ухамсарлах, үйл ажиллагаагаа үнэлэх, цэгнэх үнэлэмжийн зарчмуудыг агуулсан байдаг⁵ гэсний дагуу хүн өөрөө өөрийнхөө үүслийг танин мэдэх шаардлага гарцаагүй тулгардаг. Иймийн тулд плюралист хандлага ноёрхож буй өнөө үед хүний үүслийн талаар нэг арга зүйд баригдалгүй, олон талаас нь авч үзэх хэрэгцээний дагуу дээрх санааг гаргахыг зорьсон болно.

¹ That book. P.94

² Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001. p.96

³ That book.p. 98

⁴ That book.p. 99

⁵ Лодой.Г "Философи ба шинжлэх ухааны арга зүй" УБ. 2002. 10 дахь тал

Conclusion

In fact Marxism is related Evolutionist theory which was discovered by Charles Darwin. By outlining the link chain as "Austrelopethicus>Homo habilis>Homo erectus>Homo sapiens", the evolutionists imply that each of these species are one another's ancestor. However, recent findings of paleoantropologists have revealed that Australopithecines, Homo habilis and Homo erectus existed at different parts of the world at the same time. Moreover, a certain segment of humans classified as Homo erectus have lived up until very modern times. Homo sapiens neandarthensis and Homo sapiens sapiens /modern man/ co-existed in the same region.

Ашигласан материал

1. "Диалектик материализм" УБ. 1955.
2. Джон Хорган "Конец науки" Санкт Петербург. 2001
3. Gould, Stephen Jay "Wonderful life" New York. W.W. Norton, 1989
4. Harun Yahya "Evolution deceit" Kultur. 2001.
5. Лодой.Г "Философи ба шинжлэх ухааны арга зүй" УБ. 2002.
6. Max Planck "A physicist's view of Darwin's Theory" Evolution Trends in Plants. Vol 2в №1в 1988.
7. www.evolutiondeceit.com
8. www.websophia.com/aphorisms/science.html
9. www.philosophy.ru